



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/652

Улаанбаатар хот

Цэргийн албаны ээлжит татлагыг үргэлжлүүлэн  
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1227 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хан-Уул дүүрэгт цэргийн жинхэнэ албанд иргэдийг татах ажлыг 2024 оны 10 дугаар сарын 22, 23, 24-ний өдрүүдэд үргэлжлүүлэн зохион байгуулсугай.

2. Цэрэг татлагын ажлыг үргэлжлүүлэн зохин байгуулахтай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (З.Буянт) -т даалгасугай.

2.1. Дүүргийн цэрэг татлагын товчоо ээлжит цэрэг татлагыг дүүргийн эрүүл мэндийн төвийн байрлалд зохион байгуулж, төрийн захиргааны байгууллагын албан тушаалтнуудыг ажиллуулах;

2.2. Цэрэг татах ажлыг зохион байгуулахад ашиглагдах байр, тээврийн хэрэгсэл, бусад хэрэгцээт эд материалыг бэлтгэж, шаардагдах хөрөнгийг гаргах;

2.3. Засгийн газрын 2017 оны 144, 2019 оны 441 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, залуучуудыг цэргийн жинхэнэ албанд тэнцүүлэн авч, ээлжит цэрэг татахтай холбогдуулан ирүүлсэн эрх бүхий албан тушаалтны үүрэг, даалгавар, зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх;

2.4. Цэргийн зарлан дуудах мэдэгдэл аваад заасан газар тогтоосон хугацаанд ирээгүй иргэдийг бүрэн хамруулж, ээлжит цэрэг татлагын ирцийг нэмэгдүүлж, цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагаас ирсэн хяналтын тоон даалгаврыг биелүүлэх;

2.5. Дүүргийн эрүүл мэндийн төвд оношилгоог явуулж, нарийн мэргэжлийн эмч, сувилагч нарыг эм, эмнэлгийн багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах;

2.6. Иргэдэд батлан хамгаалах хууль тогтоомж, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчилж, иргэнийг хуулийн дагуу цэргийн алба хаах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллах;

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга хурандаа Д.Баасанхүүд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЦЭРЭН

1720011802